



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/218

Чингис хот

Тусгай зөвшөөрөл шинээр
олгох, сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5-ын "а, г", Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3.5, 19.3.8, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.5, 12 дугаар зүйлийн 12.1, 16 дугаар зүйлийн 16.2, 16.2.2, Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн хурлын 2018 оны 53 дугаар тогтоолын 5.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох комиссын 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн тусгай зөвшөөрлийг шинээр олгох эмийн сангуудын нэрсийг хавсралтаар баталж, тус бүр 1 жилийн хугацаатай олгосугай.

2. Дадал суманд үйл ажиллагаа явуулж байгаа "Амирлангуй арвижих" эмийн сангийн тусгай зөвшөөрлийг 1 жилээр сунгасугай

3. Дээрх эмийн сангуудын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Мэндбаяр)-д даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох комиссын дарга бөгөөд аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Г.Лхагвахатан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011434



Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа
эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгох байгууллагуудын нэрс

№	Тусгай зөвшөөрөл эзэмших байгууллагын нэр	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ олгосон хугацаа
1	Жаргалтхаан сумын "Хишиг тухан ХХК" эмийн сан	1 жил
2	Батноров сумын "Болортайван ХХК" эмийн сан	1 жил
3	Баян-Адарга сумын "Онон фарм ХХК" эмийн сан	1 жил
4	Норовлин сумын "Улз тун ХХК" эмийн сан	1 жил
5	Өмнөдэлгэр сумын "Далерон ХХК" эмийн сан	1 жил
6	Баян-Овоо сумын "Гүрэм Оюут ХХК" эмийн сан	1 жил
7	Цэнхэрмандал сумын "Өргөн баян хангай ХХК" эмийн сан	1 жил
8	Биндэр сумын "Биндэр амгалант эрдэнэ ХХК" эмийн сан	1 жил
9	Баянмөнх сумын "Мөнхрөх гэрэлт тун ХХК" эмийн сан	1 жил
10	Хэрлэнбаян-Улаан тосгоны "Ар цэнхэр ХХК" эмийн сан	1 жил
11	Батноров сумын "Амгаланбуян" ХХК-Ар вижих үр" эмийн сан	1 жил
12	Дэлгэрхаан сумын "Эрдэнэ бодис" ХХК	1 жил